

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН
2025 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Тайлан бэлтгэсэн: Ж.БОЛОРМАА

Миний бие Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүний үүргийг биелүүлж, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ)-ны дарга, Аудитын хорооны гишүүнээр тайлант хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд ТУЗ, ЦУНДХ, Аудитын хорооны ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцож, холбогдох асуудалд саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дараах хугацаанд хуралдав.

- 1.1. 2025.07.04-ний өдөр;
- 1.2. 2025.07.25-ны өдөр;
- 1.3. 2025.08.08-ны өдөр;
- 1.4. 2025.09.12-ны өдөр;
- 1.5. 2025.09.26-ны өдөр;
- 1.6. 2025.10.28-ны өдөр;
- 1.7. 2025.11.14-ний өдөр;
- 1.8. 2025.12.19-ний өдөр;
- 1.9. 2025.12.25-ны өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн асуудлуудыг хэлэлцэн, холбогдох шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Худалдаа, хөгжлийн банкны стратегийн зорилт, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны улирлын тайлантай танилцах, үнэлгээ дүгнэлт өгөх;
2. ХХБ-ны 2026 онд баримтлах Эрсдэлийн аппетитыг хэлэлцэн батлах;
3. Банкны засаглалтай холбоотой бодлого, журам, зааврыг хэлэлцэн батлах;
4. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
5. Банкны эзэмшилд байгаа хувьцааг худалдах зөвшөөрөл өгөх;
6. Банкны 2026 оны стратегийн зорилт болон санхүүгийн төсвийг хэлэлцэн батлах;
7. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;
8. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татах хэлцлийн тухай;
9. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах;
10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны улирлын тайлантай танилцах;
11. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэх бусад асуудал.

Тайлант хугацаанд ЦУНДХ нь нийт 4 удаа хуралдаж, Банкны хороодын гишүүдийн өөрчлөлт, Гүйцэтгэх удирдлагын багийн томилгоо, хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бол Аудитын хороо нь ХХБ-ны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, ДАГ-ын 2025 оны Аудитын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эсэх зэрэг асуудлыг хэлэлцсэн байна.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан.

Тайлант хугацаанд буюу 2025 оны сүүлийн хагас жилд нийт 14 сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗ-ын дэргэдэх Ажлын алба болон Банкны удирдлага, газар нэгжээс хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Тайлан бэлтгэсэн: Ж.ДЭЛГЭРСАЙХАН

Миний бие Компанийн тухай хууль, Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, ХХБ-ны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Тайланг бэлтгэсэн болно.

Тайлант хугацаанд буюу 2025 оны 10-р сарын 28-ны өдрөөр гишүүнээс чөлөөлөгдөх хүртлээ Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад оролцов.

- 1.1. 2025.07.04-ний өдөр;
- 1.2. 2025.07.25-ны өдөр;
- 1.3. 2025.08.08-ны өдөр;
- 1.4. 2025.09.12-ны өдөр;
- 1.5. 2025.09.26-ны өдөр;
- 1.6. 2025.10.28-ны өдөр.

2. Аудитын хорооны хурал дараах хугацаанд хуралдав.

- 2.1. 2025.07.08-ны өдөр;
- 2.2. 2025.07.22-ны өдөр;
- 2.3. 2025.09.25-ны өдөр.

3. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал хуралдсан байдал.

- 3.1. 2025.07.25-ны өдөр;
- 3.2. 2025.10.23-ны өдөр;

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай холбогдон гарсан дараахь шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй. Үүнд:

1. ТУЗ-ийн даргыг сонгох тухай;
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, гишүүдийг томилох тухай;
3. Зээлийн өр төлбөрт хураан авсан хөрөнгө худалдах тухай;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, биелэлтэнд хяналт тавьж, улирал, хагас жилийн гүйцэтгэлтэй танилцах, санал зөвлөмж өгөх;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ХХБ-ны засаглалтай холбоотой бодлого, журмуудыг батлах;
7. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх хүсэлтийг шийдвэрлэх, дэмжин баталгаажуулах;

8. ХХБ-ны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох, гэрээ байгуулах зөвшөөрөл өгөх;
9. Банкны бүтцэд өөрчлөлт оруулах;
10. ДАГ-ын Аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай;
11. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт татах зөвшөөрөл олгох зэрэг асуудлууд болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй 14 хэлцлүүд ТУЗ-н хурлаар орж хэлэлцэгдсэн, тухай бүрд хуралд оролцож өөрийн саналыг өгч оролцлоо. Эдгээр сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хэлэлцэх явцад ТУЗ-н хараат бус гишүүний үүргийн хүрээнд хууль эрх зүйд нийцтэй байдал, Монголбанкны тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах байдал, комплайнсын хүрээнд нийцтэй зэргийг тодруулж, тайлбар авч ажиллалаа.

Тайлант хугацаанд хуралд оролцохдоо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- Банкны үйл ажиллагаа удирдлага зохион байгуулалт,
- Банкны бодлого, стратеги, төлөвлөлт хэрэгжилтийн асуудлаар;
- Банкны үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын чиглэлээр;
- Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, түүний хяналт, үнэлгээний асуудлаар;
- Дотоод аудитын үйл ажиллагаа, тайлагналыг сайжруулах хүрээнд;
- ТУЗ-н дэргэдэх хороо, ажлын албаны дүрэм журамны хүрээнд;

Мөн аудитын хорооны дарга, эрсдэлийн хорооны гишүүний хувиар дараах чиглэлд анхааран ажиллалаа. Үүнд:

- Аудитын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сайжруулах, тайланг илүү үр дүнтэй болгох
- Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгож байгаа шалгуур үзүүлэлт;
- Банкны тогтворжуулах төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, түүний гүйцэтгэл;

ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны даргаар ажиллахдаа Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих ТУЗ-ийн хараат бус гишүүний эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг чармайлаа.

Тайлан бэлтгэсэн: Г.БАТЖАРГАЛ

Миний бие Г.Батжаргал нь 2025 оны 7-р сарын 1-ний өдрөөс “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн томилогдон ажилласнаас гадна ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

2025 оны 2-р хагас жилийн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, ЦУНДХ, ЭУХорооны ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцсон.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 8 удаа цахимаар хуралдаж, 1 удаа саналын хуудсаар санал авсан болно. Үүнд:

- 1.1. 2025.07.04-ний өдөр;
- 1.2. 2025.07.25-ны өдөр;
- 1.3. 2025.08.08-ны өдөр;
- 1.4. 2025.09.12-ны өдөр;
- 1.5. 2025.09.26-ны өдөр;
- 1.6. 2025.10.28-ны өдөр;
- 1.7. 2025.11.14-ний өдөр;
- 1.8. 2025.12.19-ний өдөр;
- 1.9. 2025.12.25-ны өдөр;

Дээрх хурлуудад

- ТУЗ-ийн дарга сонгох тухай;
- ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, гишүүдийг томилох тухай;
- Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, стратегийн зорилт, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, улирал, жилийн гүйцэтгэлтэй танилцах;
- Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
- Тогтвортой хөгжлийн хорооны ажиллах журам батлах тухай;
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татах тухай;
- Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх, баталгаажуулах;
- Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан;
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц;
- Зээлийн эрсдэлийн болон авлагын эрсдэлийн сангаас зээл болон авлага хаах тухай;
- ХХБ-ны 2026 онд баримтлах эрсдэлийн аппетит батлах тухай;
- ТУЗ-ийн эрхийн хүрээнд шийдвэрлэх бусад асуудлуудыг хэлэлцэхэд хурлын материалтай нэгбүрчлэн танилцаж, шаардлагатай бол нэмэлт тодруулга авсны үндсэн дээр өөрийн санал дүгнэлтээ гаргаж ажиллав.

2. Эрсдэлийн удирдлагын хорооны даргын хувьд хийсэн ажил:

Тайлант хугацаанд ЭУХороо нь нийт 2 удаа хуралдаж, ХХБ-ны Зээлийн багцын эрсдэлийг удирдах зааврыг хүчингүй болгох болон Банкны Эрсдэлийн аппетитын улирлын гүйцэтгэлийг хэлэлцэж шийдвэрлэв.

3. ЦУНДХорооны гишүүний хувьд хийсэн ажил:

Хорооны гишүүний хувьд 4 удаагийн хуралд цахимаар оролцож, Банкны бүтцийн өөрчлөлт, Хороодын гишүүдийн өөрчлөлт, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг чөлөөлөх, хараат бу гишүүнд нэр дэвшүүлэх, ГЗО-ийн хөдөлмөрийн гэрээг сунгах зэрэг асуудлыг хэлэлцэхэд оролцож саналаа өгсөн болно.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн байр сууриа илэрхийлж ажилласан болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Тайлант хугацаанд буюу 2025 оны сүүлийн хагас жилд 13 сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудал ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн болно.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗДАА болон Банкны удирдлага, газар нэгжээс хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.